

Цаг уур, орчны шинжилгээний газраас 2023 онд зохион байгуулсан сургалтын жилийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 04

№	Сургалтын сэдэв	Сургалтад оролцогчид	Сургалтын хугацаа	Хугацаа хоногоор	Сургалтын хэлбэр	Зохион байгуулах хэлтэс нэгж	Биелэлт
----------	------------------------	-----------------------------	--------------------------	-------------------------	-------------------------	-------------------------------------	----------------

1	2	3	4	5	7	8	9
1	Удирдах ажилтны сургалт, семинар	Газрын харьяа байгууллагын төв, орон нутгийн дарга, захирал нар	1 сард	2	Танхим	Бүх хэлтсүүд	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын 2022 оны шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлын нэгдсэн дүн, Албаны 100 жилийн ойг утгаж хийх ажлууд, Төсвийн шууд захирагч нарын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянан баталгаажуулах, салбарын хэмжээнд 2023 онд хийж хэрэгжүүлэх арга хэмжээ, нийт албан хаагчдын нийгмийн баталгаа, цалин хөлс, тулгамдаж буй асуудлуудын талаар нэгдсэн уулзалт, хэлэлцүүлгийг 2023 оны 01 дүгээр сарын 19-21-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсан.
2	Цаг агаарын мэдээний хөтлөгч, редакторуудад зориулсан чадамж олгох сургалт	Бүх телевизийн сэтгүүлч нар	5 сард	1	Танхим	Урьдчилан мэдээлэх хэлтэс	Тус газраас хэвлэл мэдээллийн байгууллагын холбогдох ажилтнуудад зориулсан "Цаг агаар ба хэвлэл мэдээлэл" сэдэвт сургалтыг 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулахаар газрын даргын тушаал гарсан бөгөөд хөтөлбөрийг холбогдох байгууллагуудад 01/1159 тоот албан бичгээр хүргүүлсэн байгаа. Нийт 35 оролцогчдод 1 өдрийн сургалт зохион байгуулна.

1	2	3	4	5	7	8	9
3	Төв, орон нутгийн синоптик инженерүүдийн сургалт	Төв, орон нутгийн синоптик инженерүүд	4 сард	5	Танхим	Урьдчилан мэдээлэх хэлтэс	2023 оны 4 дүгээр сарын 24-28-ны өдрүүдэд Аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүдийн синоптик инженерүүдийн цахим, танхим хосолсон мэргэшүүлэх сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд нийт 20 аймгийн 41 тэнхологич, синоптикууд инженерүүд идэвхтэй хамрагдсан. Хөтөлбөрийн дагуу хэлтсийн дарга, ахмад синоптикууд, МУИС-ийн багш, технологич инженерүүд хичээл заав.
4	Цаг агаарт зориудаар нөлөөлөх тусгай эрх олгох	Экспедицүүдийн бүрэлдэхүүн	3 сард	2	Цахим	Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтэс	Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицүүдийн инженерүүдийн мэргэшүүлэх сургалтыг 03 сарын 27, 28 -ны өдрүүдэд зохион байгуулж Улсын хэмжээний цаг агаарт зориудаар нөлөөлөх 46 экспедицийн инженер, ЦУОШГазрын холбогдох мэргэжилтэн, алба хаагчид нийт 57 хүн оролцлоо. Тус сургалтаар пиротехникийн хэрэгслийн бүтэц, онцлог, пиротехникийн хэрэгсэл ашиглах, тээвэрлэх, хадгалах үеийн аюулгүй ажиллагааны шаардлага, пиротехникийн хэрэгсэл ашиглах, тээвэрлэх, хадгалах үеийн аюулгүй ажиллагааны шаардлага, Хууль, эрх зүйн талаар болон цаг уурын ажиглалт, зааврын талаар нийт 16 цагийн хичээл орж шалгалт авч тэнцсэн алба хаагчдад тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах эрхийн үнэмлэх олгосон байна.
5	ЦАЗН үйл ажиллагааны хууль, заавар, журамын шинэчлэл /гэрчилгээ сунгах/	Экспедицүүдийн дарга, ХААБ инженерүүд	4 сард	2	Танхим	Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтэс	Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны заавар шинэчлэн батлагдсан тул сургалтыг 2024 оны 1 дүгээр улиралд зохион байгуулахаар хойшлуулсан.

1	2	3	4	5	7	8	9
6	Ус судлалын инженерийн сургалт	Газрын харьяа төв, орон нутгийн усны инженерүүд	3 сард	5	Танхим	Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтэс	Ус судлалын инженерийн сургалтыг 2023 оны 4 дүгээр сарын 3-6-ны өдрүүдэд зохион байгуулж орон нутгийн 18 усны судлалын инженер, УЦУОСМХ-ийн хэлтсийн 12 албан хаагч хамрагдсан. Сургалтын хөтөлбөрийн дагуу 26-н сэдвээр холбогдох мэргэжилтнүүд хичээл заасан. Мөн инженерийн зэрэг тогтоо шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулсан ба 2 хүн II дугаар зэрэг, 16 хүн III зэргийн шалгалт өгсөн байна.
7	Сорилтын лабораторийн итгэмжлэл MNSISO/IEC 1702552018	Газрын харьяа байгууллагын төв, орон нутгийн лабораторийн инженер, техникчид	5 сард	1	Цахим	Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтэс	"Сорилтын лабораторийн итгэмжлэл MNSISO/IEC 1702552018" сургалтыг 2023 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр зохион байгуулсан бөгөөд 21 аймгийн УЦУОШТ-ийн лабораторийн 21 инженер, техникчид оролцсон.
8	Байгаль орчны цацрагийн хяналт шинжилгээ	Газрын харьяа байгууллагын төв, орон нутгийн техникчид	6 сард	1	Цахим	Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтэс	Байгаль орчны цацрагийн хяналт шинжилгээний сургалтыг 2023 оны 6 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж 21 аймаг, Улаанбаатар хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүд болон БОХЗТЛ-ийн инженер, техникчидийн мэргэшүүлсэн бөгөөд нийт 99 инженер, техникч хамрагдсан.

1	2	3	4	5	7	8	9
9	Иргэний агаарын тээврийн нислэгт цаг агаарын бодит мэдээний үйлчилгээ үзүүлдэг инженер, техникчдэд зориулсан давтан сургалт	Төв, орон нутгийн инженер, техникч нар	3 сард	3	Танхим болон цахим	Нислэгийн цаг уурын төв	Нислэгийн цаг уурын төвөөс 2 жил тутамд зохион байгуулдаг Иргэний агаарын тээврийн нислэгт цаг уурын үйлчилгээ үзүүлэх шалгуур үзүүлэлтийг хангасан инженер, техникчдэд зориулсан давтан сургалтыг 2023 оны 3 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд батлагдсан хөтөлбөрийн дагуу танхим болон цахимаар хослуулан зохион байгуулсан. Сургалтад холбогдох аймгууд болон харьяа байгууллагуудын 86 инженер, техникчид оролцов.
10	Цаг уурын ажиглагч бэлтгэх сургалт	Газрын харьяа байгууллагын төв, орон нутгийн техникч нар	6 сард	30	Танхим	"Ус цаг уурын хөгжлийг дэмжих төв" ТББ	Цаг уурын ажиглагчийн чадамж эзэмшүүлэх сургалтыг 2023 оны 04 дүгээр сард "Ус цаг уурын хөгжлийг дэмжих төв ТББ"-тай хамтран зохион байгуулж хөтөлбөрийн дагуу 140 цагийн хичээл орж нийт 35 сургач эрхийн үнэмлэхээ гардаж авсан.

Нэмэлтээр зохион байгуулагдсан сургалт

1	"Цаг агаарын нэлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ" сэдэвт сургалт	Газрын харьяа байгууллагын төв, орон нутгийн цаг уур, уур амьсгал болон ус судлалын инженерүүд	10 сард	1	Танхим	УЦУОСМХ, АДАПТ төсөл	2023 оны 10 сарын 27-ны өдөр "Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь" төсөлтэй хамтран "Цаг агаарын нэлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ" сэдэвт сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтад төв болон орон нутгийн УЦУОШТ-ийн цаг уур, уур амьсгал, ус судлалын нийт 120 инженер оролцлоо.
---	-------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------	---------	---	--------	----------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

1	2	3	4	5	7	8	9
2	Ус судлалын ажиглагчийн сургалт	Газрын харьяа төв, орон нутгийн техникич нар	11 сард	30	Танхим	"Ус цаг уурын хөгжлийг дэмжих төв" ТББ	2023 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч ус судлалын харуулын сургалтад хамрагдах хүсэлтийг олон албан хаагч гаргасан тул уг сургалтыг "Ус цаг уурын хөгжлийг дэмжих" төв ТББ-тай хамтран 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс 11 дүгээр 23-ны өдрүүдэд нийт 140 цагийн хөтөлбөрөөр зохион байгууллаа. Амжилттай суралцсан 34 ус судлалын ажиглагчдад ЦУОШГ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/233 дугаар тушаалаар "Ус судлалын ажиглагч" үнэмлэхийг олгосон.

Хянасан: Захиргаа, аудитын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Галцог

Тайланг нэгтгэсэн: Б.Эрдэнэмэнх Ахлах мэргэжилтэн Б.Эрдэнэмэнх



УХА0160